



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны "Төрийн өмчит зарим хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай" 243 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Буянт-Ухаа спортын ордон" төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгийг 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангаар "Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв" төрийн өмчит үйлдвэрийн газарт шилжүүлэх, нэгтгэх Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:

Ц.Баяр-Эрдэнэ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын
хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Цэрэнболд

Биеийн тамир, спортын улсын хорооны Санхүү,
хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
/Зөвшилцсөнөөр/

Г.Дэлгэрмаа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын
хэлтсийн мэргэжилтэн

П.Уранмандах

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн
мэргэжилтэн

Б.Наран-Идэр

"Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын
төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал

Л.Энхбаяр

"Буянт-Ухаа спортын ордон" төрийн өмчит
үйлдвэрийн газрын захирал

Б.Жамцгэрэл

"Буянт-Ухаа спортын ордон" төрийн өмчит
үйлдвэрийн газрын Ерөнхий нягтлан бодогч

132013682

Э.Мөнхболд

"Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын нягтлан бодогч

Нарийн бичиг:

Г.Нямдаваа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын
хэлтсийн мэргэжилтэн


Д.Сонинбилэг

"Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв"
төрийн өмчит үйлдвэрийн газрын Сургалтын албаны
дарга

2.Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Ажлын хэсгийн нэгдсэн санал, дүгнэлтийг 2023 оны 10 дугаар сард багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг /Ц.Баяр-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The signature is a cursive, stylized name. The stamp contains Mongolian text, including the word 'ДАРГА' (Director) and the name 'Б.ЦЭНГЭЛ' (B. Tsendgal).

Б.ЦЭНГЭЛ

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг: Зорилго

“Буянт-Ухаа спортын ордон” төрийн өмчит үйлдвэрийн газрын хаалтын балансыг гаргаж, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт шилжүүлэх талаар цаашид авах арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Ажлын хэсэг энэхүү удирдамжийг баримтална.

Хоёр: Хийгдэх ажлын чиглэл

1. “Буянт-Ухаа спортын ордон” төрийн өмчит үйлдвэрийн газрын эд хөрөнгийг 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан балансын дүнгээр “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт шилжүүлэх;

2. Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн хүрээнд хуулийн этгээдийн үйл ажиллагаанд үүссэн архивын баримтыг бүрдүүлэн Архивын ерөнхий газарт хүлээлгэн өгөх;

3. “Буянт-Ухаа спортын ордон” төрийн өмчит үйлдвэрийн газрын хаалтын балансыг гаргах;

4. “Буянт-Ухаа спортын ордон” төрийн өмчит үйлдвэрийн газрын хаалтын балансын /эд хөрөнгийг тоолж бүртгэх, өр авлагын тооцоо нийлэх гэх мэт/ дүнгээр “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт хүлээлгэж өгөх.

Гурав: Үр дүн, хугацаа

Ажлын хэсгийн тайлан, цаашид авах арга хэмжээний талаарх санал дүгнэлтээ 2023 оны 10 дугаар сард багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулах.

.....000.....